



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 83

Баянхутаг сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдсэн “Мал угаалгын ванн” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэнд - Мал эмнэлгийн улсын байцаагч
Гишүүд: Х.Энхцэцэг - Санхүүгийн албаны дарга
Б.Бат-Эрдэнэ- ХХААТ-ийн мэргэжилтэн
Д.Алтанчимэг- Улаан-Өндөр багийн Засаг дарга
А.Чимэддондов- ЗДТГ-ын нярав

2. Уг ажлыг зургийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавин хүлээж авахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Мал угаалгын ванны үнэлгээг тогтоон Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэж авахыг Засаг даргын тамгын газрын дарга /Б.Золбоо/, нягтлан бодогч /Г.Пүрэвдулам/, нярав /А.Чимэддондов/ нарт даалгасугай.

4. Ажил хүлээлцсэн акт, гүйцэтгэлийн тайлан зэрэг холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн тус төслийн үлдэгдэл санхүүжилтийг олгохыг нягтлан бодогч /Х.Энхцэцэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.МӨНХНАРАН